ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
СТРАТЕГИ, БОДЛОГО, ИННОВАЦ, ХӨГЖЛИЙН АЛБА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2025 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот
2026 он

Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн хошууч С.Энхбаатар
Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Уянга
Чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Хулангоо
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад М.Ганзул
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Балжин
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Тамир
Мэргэжилтэн, цагдаагийн ахмад Б.Мөнхтөр
Цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч О.Чинбат

Хянасан: Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны дарга, цагдаагийн хурандаа С.Тайван
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Жанчивдорж

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хуулбарлах, хэвлэн олшруулахыг хориглоно.

ГАРЧИГ

ГАРЧИГ		**2**
НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ		**3**
ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ		**10**
ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ		**83**
ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ		**245**
4.1	Хүнийг алах гэмт хэрэг	**245**
4.2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	**249**
4.3	Хүчиндэх гэмт хэрэг	**253**
4.4	Хулгайлах гэмт хэрэг	**257**
4.5	Халаасны хулгайн гэмт хэрэг	**261**
4.6	Орон байрны хулгайн гэмт хэрэг	**264**
4.7	Мал хулгайлах гэмт хэрэг	**267**
4.8	Дээрэмдэх гэмт хэрэг	**271**
4.9	Залилах гэмт хэрэг	**275**
4.10	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	**279**
4.11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	**281**
4.12	Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг	**285**
4.13	Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	**289**
ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ		**292**
5.1	Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	**292**
5.2	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	**296**
5.3	Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг	**301**
5.4	Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	**305**
5.5	Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг	**309**
5.6	Гадаадын иргэдээс хохирсон, холбогдсон гэмт хэрэг	**313**
ЗУРГАА. ГЭМТ ХЭРГИЙН ТАРХАЛТ		**316**
6.1	Зарим төрлийн гэмт хэргийн тархалт	**316**
6.2	Уул уурхай ба гэмт хэрэг	**338**
6.3	Ганц бие эрэгтэйчүүд ба гэр бүлийн хүчирхийлэл	**342**
ДОЛОО. ГЭМТ ХЭРГИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ		**348**

Нэг. УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс **311.310** гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 121.710 буюу 39.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 189.600 буюу 60.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.


Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 12.297 буюу 3.8 хувь, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 376 буюу 0.3 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 11.921 буюу 5.9 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 42.085 буюу 34.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 72.243 буюу 59.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 2007 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 126.203 буюу 66.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 59.532 буюу 31.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1535 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна


1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 47.480 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 2807 буюу 6.3 хувиар өссөн нь сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл 6.4 хувийн өсөлттэй байна.


1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (орон нутаг).



1.2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг (нийслэл).



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Улсын хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 560.876 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 4.6%-тай байж, 2030 онд 59.347 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.


1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 40000 буюу 84.2 хувь нь хөнгөн, 7480 буюу 15.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 2.7, хүнд хэрэг 30.8 хувиар тус тус өссөн байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл		Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
			2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		852	829	-2.7	1.7
	Үүнээс: Хүнийг алах		191	186	-2.6	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		8935	9381	5.0	19.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		123	155	26.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		847	838	-1.1	1.8
	Үүнээс: Хүчиндэх		658	633	-3.8	1.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		586	560	-4.4	1.2
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		42	5	-88.1	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		48	52	8.3	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		66	45	-31.8	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		27971	28419	1.6	59.9
	Үүнээс:	Хулгайлах	7626	7017	-8.0	14.8
		Дээрэмдэх	568	672	18.3	1.4
		Залилах	15889	16906	6.4	35.6
		Малын хулгай	508	525	3.3	1.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг		336	311	-7.4	0.7
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		378	689	82.3	1.5
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		166	180	8.4	0.4
13	Авлигын гэмт хэрэг		17	19	11.8	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		321	328	2.2	0.7
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг		489	457	-6.5	1.0
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		24	17	-29.2	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		406	793	95.3	1.7
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг		3167	4536	43.2	9.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих		3158	4532	43.5	9.5
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		21	21	0.0	0.0

1.6. Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл.





Гэмт хэргийн бүтцээр авч үзвэл, нийт гэмт хэргийн 59.9 хувийг Өмчлөх эрхийн эсрэг, 19.8 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг түс түс эзлэх бөгөөд сүүлийн 10 жилд дээрх 2 төрлийн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 80.0-85.0 хувийг тогтвортой эзэлж байна.

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг,араг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 7366 буюу 15.5 хувь нь Даваа гарагт, 7236 буюу 15.2 хувь нь Мягмар гарагт, 7070 буюу 14.9 хувь нь Лхагва гарагт, 6972 буюу 14.7 хувь нь Пүрэв гарагт, 7050 буюу 14.8 хувь нь Баасан гарагт, 6028 буюу 12.7 хувь нь Бямба гарагт, 5758 буюу 12.1 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 17.451 буюу 36.8 хувь нь 06:00-14:00 цагт, 12.694 буюу 26.7 хувь нь 14:00-19:00 цагт, 5539 буюу 11.7 хувь нь 19:00-22:00 цагт, 11.796 буюу 24.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 16.128 буюу 34.0 хувь нь гэр орон сууцанд, 8198 буюу 17.3 хувь нь гудамж талбайд, 4852 буюу 10.2 хувь нь олон нийтийн газарт, 217 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 499 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 216 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 3849 буюу 8.1 хувь нь аж ахуйн нэгжид, 4155 буюу 8.8 хувь нь авто замд, 9366 буюу 19.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 7659 буюу 16.1 хувь нь согтуугаар, 5104 буюу 10.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1618 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 1135 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 1677 буюу 3.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 14.638 буюу 30.8 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 104.536 хэрэгт хэрэг бүртгэлт, 5135 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 109.671 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 39.356 урьд оны үлдэгдэл хэрэг, 66.109 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 187, урьд оны хэрэгсэхгүй, хэрэг бүртгэлтийн хэрэг хааснаас сэргээсэн 4019 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 71.654 буюу 65.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-41.992 буюу 58.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-19.704 буюу 27.5 хувийг шүүхэд шилжүүлж;
-320 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож;
-7980 буюу 11.1 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-1658 буюу 2.3 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 65.3 хувь, хуулийн анхны хугацаанд 93.8 хувийг шийдвэрлэж, 3940 хүн, 1 хуулийн этгээдэд холбогдох 39.615 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Улсын хэмжээнд 48.2 хувь, нийслэлд 43.7 хувь, орон нутагт 60.0 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 1.2 нэгжээр, нийслэлд 1.6 нэгжээр тус тус өсөж, орон нутагт 2.5 нэгжээр буурсан байна.

Сүүлийн 20 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 44.581 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 4265 хэрэг буюу 10.6 хувиар, үүнээс 21.484 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 2543 буюу 13.4 хувиар тус тус өссөн.


Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 26.248 хүн гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан нь өмнөх онтой харьцуулахад 957 буюу 3.8 хувиар өссөн.

Яллагдагчдын 3611 буюу 13.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 1857 буюу 34.0 хувиар өсөж, 1540 буюу 5.9 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байгаа нь 135 буюу 8.1 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 43771 иргэн, 226 хуулийн этгээд хохирч, үүнээс 1114 хүн нас барж, 10783 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 859 буюу 2.0 хувиар, хуулийн этгээд 104 буюу 85.2 хувиар, нас барсан хүн 123 буюу 12.4 хувиар, гэмтсэн хүн 180 буюу 1.7 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 806.3 тэрбум төгрөгийн хохирлын 300.5 тэрбум төгрөг буюу 37.3 хувийг нөхөн төлүүлж, 2859.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 109.228.4 сая төгрөг буюу 15.7 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 5759.4 сая төгрөг буюу 1.9 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 2152.2 сая төгрөг буюу 42.9 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 4.957.151 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 1.577.737 буюу 46.7 хувиар, 4.942.915 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1.572.522 буюу 46.7 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 4.669.487 буюу 94.2 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 151.035 буюу 3.0 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 12840 буюу 0.3 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4505 буюу 0.1 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 119.284 буюу 2.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 4765337 иргэн, 137548 хуулийн этгээдийг 110.9 тэрбум төгрөгөөр торгох, 9935 хүнийг баривчлуулах, 24104 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 5926 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 1495754 буюу 45.7 хувиар, хуулийн этгээд 72.963 буюу 2.1 дахин, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 4032 буюу 20.1 хувиар, баривчлуулж, эрх хасах шийтгэл 2037 буюу 52.4 хувиар тус тус өсөж, баривчлуулсан шийтгэл 2246 буюу 18.4 хувиар буурсан байна.

2025 онд улсын хэмжээнд нийт 12.545 хүн эрүүлжүүлж, 38.456 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 4835 буюу 62.7 хувиар, саатуулсан хүн 1102 буюу 3.0 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---

Хоёр. НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн хэмжээнд 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 178.238 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 85.240 буюу 47.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 92.998 буюу 52.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 19.433 буюу 9.8 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 4055 буюу 4.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 15.378 буюу 14.2 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 22.202 буюу 26.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 57.770 буюу 67.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1602 буюу 1.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 37.386 буюу 40.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 53.963 буюу 58.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 331 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна


1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 33144 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1021 буюу 3.2 хувиар өсөж, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн 69.8 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (нийслэл).



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Нийслэлийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 357.833 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 6.6%-тай байж, 2030 онд 45.595 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 29512 буюу 89.0 хувь нь хөнгөн, 3632 буюу 11.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 0.9, хүнд хэрэг 25.9 хувиар тус тус өссөн байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	*Гэмт хэргийн төрөл*		*Бүртгэгдсэн хэрэг*		*Өсөлт, бууралтын хувь*	*Нийт гэмт хэрэгт эзлэх хувь*
			2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		631	550	-12.8	1.7
	Үүнээс: Хүнийг алах		104	100	-3.9	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		5173	5573	7.7	16.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		481	502	4.4	1.5
	Үүнээс: Хүчиндэх		365	387	6.0	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		444	427	-3.8	1.3
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		13	2	-84.6	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		39	32	-17.9	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		55	32	-41.8	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		22718	22547	-0.8	68.0
	Үүнээс:	Хулгайлах	6041	5379	-11.0	16.2
		Дээрэмдэх	486	597	22.8	1.8
		Залилах	13560	13988	3.2	42.2
		Малын хулгай	23	36	56.5	0.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг		255	187	-26.7	0.6
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		293	555	89.4	1.7

12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	128	128	0.0	0.4
13	Авлигын гэмт хэрэг	9	4	-55.6	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	191	203	6.3	0.6
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	72	36	-50.0	0.1
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	16	9	-43.8	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	362	606	67.4	1.8
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1239	1742	40.6	5.3
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	3	9	3.0 дахин	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 5132 буюу 15.5 хувь нь Даваа гарагт, 5075 буюу 15.3 хувь нь Мягмар гарагт, 4999 буюу 15.1 хувь нь Лхагва гарагт, 4841 буюу 14.6 хувь нь Пүрэв гарагт, 4870 буюу 14.7 хувь нь Баасан гарагт, 4213 буюу 12.7 хувь нь Бямба гарагт, 4014 буюу 12.1 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 13.640 буюу 41.2 хувь нь 06:00-14:00 цагт, 8704 буюу 26.3 хувь нь 14:00-19:00 цагт, 3398 буюу 10.3 хувь нь 19:00-22:00 цагт, 7402 буюу 22.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
0:00	29	26	30	26	23	30	23	187
1:00	141	151	156	159	148	161	162	1078
2:00	185	218	200	164	169	175	171	1282
3:00	70	83	74	83	77	104	85	576
4:00	142	143	130	131	149	141	146	982
5:00	173	178	158	163	163	185	127	1147
6:00	32	42	49	45	54	43	48	313
7:00	164	171	142	151	145	119	132	1024
8:00	273	253	273	306	234	205	181	1725
9:00	83	87	84	90	88	72	63	567
10:00	472	467	517	439	430	343	352	3020
11:00	395	406	405	404	418	288	311	2627
12:00	186	188	228	178	185	172	165	1302
13:00	534	495	467	437	433	355	341	3062
14:00	443	395	419	416	394	338	315	2720
15:00	221	178	152	145	169	134	141	1140
16:00	336	360	371	329	350	271	262	2279
17:00	332	284	267	288	297	238	184	1890
18:00	97	122	89	87	88	85	107	675
19:00	216	193	190	208	220	154	194	1375
20:00	220	230	204	223	229	205	177	1488
21:00	85	76	79	66	82	69	78	535
22:00	139	152	148	139	142	155	108	983
23:00	164	177	167	164	183	171	141	1167
Нийт	5132	5075	4999	4841	4870	4213	4014	33144

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 11.774 буюу 35.5 хувь нь гэр орон сууцанд, 6581 буюу 19.9 хувь нь гудамж талбайд, 4043 буюу 12.2 хувь нь олон нийтийн газарт,

200 буюу 0.6 хувь нийтийн тээвэр, 252 буюу 0.8 хувь нь төрийн байгууллагад, 169 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 3274 буюу 9.9 хувь нь аж ахуйн нэгжид, 1730 буюу 5.2 хувь нь авто замд, 5121 буюу 15.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.


1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2466 буюу 7.4 хувь нь согтуугаар, 3442 буюу 10.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 935 буюу 2.8 хувь нь бүлэглэн, 748 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 754 буюу 2.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 11785 буюу 35.6 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 73.446 хэрэгт хэрэг бүртгэлт, 2321 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 75.767 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 29.881 урьд оны үлдэгдэл хэрэг, 42.562 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 143, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 3181 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 47.355 буюу 62.5 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-31097 буюу 65.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
-8407 буюу 17.8 хувийг шүүхэд шилжүүлж,
-192 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож,
-6605 буюу 13.9 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
-1054 буюу 2.2 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 62.5 хувь, хуулийн анхны хугацаанд 94.3 хувийг шийдвэрлэж 2605 хүнд холбогдох 29.552 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.


2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлд 43.7 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1.6 нэгжээр өсөж, улсын хэмжээний илрүүлтээс 4.5 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 32.344 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 1644 хэрэг буюу 5.4 хувиар, үүнээс 14.137 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 1207 буюу 9.3 хувиар тус тус өссөн.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь




Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 15.851 хүн гэмт хэрэгт холбогдон яллагдагчаар татагдсан нь өмнөх онтой харьцуулахад 377 буюу 2.4 хувиар өссөн.

Яллагдагчдын 2230 буюу 14.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оноос 1936 буюу 46.5 хувиар буурч, 996 буюу 6.3 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байгаа нь 151 буюу 13.2 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 31.565 иргэн, 101 хуулийн этгээд хохирч, үүнээс 610 хүн нас барж, 6388 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал нийт хохирогч 268 буюу 0.9 хувиар, хуулийн этгээд 25 буюу 32.9 хувиар, гэмтсэн хүн 351 буюу 5.8 хувиар, нас барсан хүн 83 буюу 15.7 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 721.3 тэрбум төгрөгийн хохирлын 259.5 тэрбум төгрөг буюу 36.0 хувийг нөхөн төлүүлж, 430.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 98.2 тэрбум төгрөг буюу 15.8 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 2.6 тэрбум төгрөг буюу 1.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 2418.6 сая төгрөг буюу 84.9 хувиар тус тус буурсан байна.


Тав. Зөрчил.

Нийслэлийн хэмжээнд нийт 4.073.518 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 1.545.830 буюу 61.2 хувиар, 3.921.294 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1.472.338 буюу 60.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 3,870,150 буюу 95.0 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 118.319 буюу 2.9 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 8010 буюу 0.2 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4265 буюу 0.1 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 72774 буюу 1.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 3.921.294 иргэн, 137.127 хуулийн этгээдийг 74.9 тэрбум төгрөгөөр торгох, 5230 хүнийг баривчлуулах, 7092 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 2750 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 1.472.338 буюу 60.1 хувиар, хуулийн этгээд 72.815 буюу 2.1 дахин, торгуулийн хэмжээ 24.3 тэрбум төгрөг буюу 48.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 870 буюу 14.0 хувиар тус тус өсөж, баривчлуулсан шийтгэл 1297 буюу 19.9 хувиар буурсан байна.

2025 онд улсын хэмжээнд нийт 9725 хүн эрүүлжүүлж, 32163 хүнийг саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 4711 буюу 94.0 хувиар, саатуулсан хүн 1820 буюу 6.0 хувиар тус тус өссөн байна.



---oooOooo---

2.1. БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 27607 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 14246 буюу 51.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 13361 буюу 48.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 2234 буюу 7.5 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 11.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2.6 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2845 буюу 20.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 10429 буюу 73.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 407 буюу 2.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 6326 буюу 47.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 6766 буюу 50.6 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 39 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна


1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 4765 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1209 буюу 20.2 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 14.4 хувийг эзэлж байна.

1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 60087 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 5.5%-тай байж, 2030 онд 6233 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	326	179	-147	-45.1	*18-р хороо*	227	163	-64	-28.2
2-р хороо	570	296	-274	-48.1	*19-р хороо*	155	147	-8	-5.2
3-р хороо	327	203	-124	-37.9	*20-р хороо*	325	221	-104	-32.0
4-р хороо	182	171	-11	-6.0	*21-р хороо*	116	53	-63	-54.3
5-р хороо	281	149	-132	-47.0	*22-р хороо*	112	116	4	3.6
6-р хороо	225	160	-65	-28.9	*23-р хороо*	57	68	11	19.3
7-р хороо	136	353	217	2.6 дахин	*24-р хороо*	202	161	-41	-20.3
8-р хороо	192	140	-52	-27.1	*25-р хороо*	101	81	-20	-19.8
9-р хороо	213	99	-114	-53.5	*26-р хороо*	107	189	82	76.6
10-р хороо	150	81	-69	-46.0	*27-р хороо*	60	63	3	5.0
11-р хороо	202	166	-36	-17.8	*28-р хороо*	102	52	-50	-49.0
12-р хороо	139	111	-28	-20.1	*29-р хороо*	335	160	-175	-52.2
13-р хороо	214	173	-41	-19.2	*30-р хороо*	40	124	84	3.1 дахин
14-р хороо	213	190	-23	-10.8	*31-р хороо*	64	67	3	4.7
15-р хороо	98	99	1	1.0	*32-р хороо*	79	52	-27	-34.2
16-р хороо	189	138	-51	-27.0	*33-р хороо*	41	70	29	70.7
17-р хороо	169	173	4	2.4	*34-р хороо*	25	97	72	3.9 дахин

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4447 буюу 93.3 хувь нь хөнгөн, 318 буюу 6.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 20.8 хувиар, хүнд хэрэг 10.9 хувиар тус тус буурсан байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	105	69	-34.3	1.4
	Үүнээс: Хүнийг алах	20	18	-10.0	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	929	840	-9.6	17.6
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	70	77	10.0	1.6
	Үүнээс: Хүчиндэх	49	58	18.4	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	67	50	-25.4	1.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3	-	-	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	10	11	10.0	0.2
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	10	8	-20.0	0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	4387	3266	-25.6	68.5
	Үүнээс: Хулгайлах	1232	720	-41.6	15.1
	Үүнээс: Дээрэмдэх	125	105	-16.0	2.2
	Үүнээс: Залилах	2516	2112	-16.1	44.3
	Үүнээс: Малын хулгай	-	-	-	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг	39	26	-33.3	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	45	106	2.4 дахин	2.2
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	27	14	-48.1	0.3
13	Авлигын гэмт хэрэг	-	-	-	-
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	68	45	-33.8	0.9
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	34	61	79.4	1.3
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	179	192	7.3	4.0
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 716 буюу 15.0 хувь нь Даваа гарагт, 765 буюу 16.1 хувь нь Мягмар гарагт, 729 буюу 15.3 хувь нь Лхагва гарагт, 693 буюу 14.5 хувь нь Пүрэв гарагт, 696 буюу 14.6 хувь нь Баасан гарагт, 590 буюу 12.4 хувь нь Бямба гарагт, 576 буюу 12.1 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2007 буюу 42.1 хувь нь 06:00-14:00 цагт, 1217 буюу 25.5 хувь нь 14:00-19:00 цагт, 397 буюу 8.3 хувь нь 19:00-22:00 цагт, 1144 буюу 24.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	**Нийт**
0:00	12	9	8	5	6	11	9	60
1:00	24	25	24	27	27	30	29	186
2:00	34	35	41	38	19	34	20	221
3:00	15	13	9	16	13	15	19	100
4:00	18	24	20	13	19	18	22	134
5:00	27	31	26	26	30	35	36	211
6:00	6	5	10	12	11	5	14	63
7:00	19	30	19	13	28	23	19	151
8:00	37	36	45	50	30	30	28	256
9:00	13	13	18	20	11	10	14	99
10:00	58	82	77	62	59	51	45	434
11:00	66	70	70	63	74	44	40	427
12:00	41	30	38	27	42	31	27	236
13:00	62	59	52	53	37	39	39	341
14:00	55	58	49	64	58	39	43	366
15:00	56	43	34	40	48	28	27	276
16:00	29	38	43	33	33	31	29	236
17:00	41	39	24	23	40	30	19	216
18:00	14	35	14	16	15	14	15	123
19:00	23	17	20	23	26	15	18	142
20:00	22	26	27	21	21	19	18	154
21:00	15	17	19	8	15	9	18	101
22:00	14	14	24	18	13	12	10	105
23:00	15	16	18	22	21	17	18	127
Нийт	716	765	729	693	696	590	576	4765

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1731 буюу 36.3 хувь нь гэр орон сууцанд, 1113 буюу 23.4 хувь нь гудамж талбайд, 932 буюу 19.6 хувь нь олон нийтийн газарт, 43 буюу 0.9 хувь нь нийтийн тээвэрт, 28 буюу 0.6 хувь нь төрийн байгууллагад, 17 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 552 буюу 11.6 хувь нь аж ахуйн нэгжид, 204 буюу 4.3 хувь нь авто замд, 145 буюу 3.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 314 буюу 6.6 хувь нь согтуугаар, 566 буюу 11.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 141 буюу 3.0 хувь нь бүлэглэн, 98 буюу 2.1 хувь нь хүүхэд оролцож, 93 буюу 2.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1688 буюу 35.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 12270 хэрэгт хэрэг бүртгэлт, 185 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 12455 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 6133 урьд оны үлдэгдэл хэрэг, 5842 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 10, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 470 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 8873 буюу 71.2 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-6592 буюу 74.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-1073 буюу 12.1 хувийг шүүхэд шилжүүлж;
-17 буюу 0.2 хувийг хэрэгсэхгүй болгож;
-1128 буюу 12.7 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-63 буюу 0.7 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 71.2 хувь, хуулийн анхны хугацаанд 86.5 хувийг шийдвэрлэж 302 хүнд холбогдох 3668 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 995 буюу 20.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 43.6 хувьтай байгаа нь өмнөх оноос 10.8 нэгжээр өссөн. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 0.1 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 4659 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 1122 хэрэг буюу 19.4 хувиар буурч, 2031 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 138 буюу 7.3 хувиар өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2265 хүн шалгагдсан нь өмнөх оноос 4.1 хувиар өссөн. Яллагдагчдын 312 буюу 13.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 43.8 хувиар буурч, 1953 буюу 86.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 20.5 хувиар, 124 буюу 5.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 49.4 хувиар тус тус өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4516 иргэн, 8 хуулийн этгээд хохирч, 69 хүн нас барж, 973 хүн гэмтсэн нь өмнөх оноос, хохирсон хүн 1297 буюу 22.3 хувиар, гэмтсэн хүн 96 буюу 9.0 хувиар тус тус буурч, нас барсан хүн 1 буюу 1.5 хувиар өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




/Сая төгрөгөөр/

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 73.2 тэрбум төгрөгийн хохирлын 44.4 тэрбум төгрөг буюу 60.7 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 1.0 тэрбум төгрөг буюу 1.5 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 11.2 тэрбум төгрөг буюу 33.8 хувиар өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 37169 зөрчил шалгасан нь өмнөх оноос 15.5 хувиар, 36247 зөрчлийг шийдвэрлэсэн нь 14.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 3497 буюу 9.4 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 23129 буюу 62.2 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 750 буюу 2.0 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1664 буюу 4.5 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 8129 буюу 21.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 35699 иргэн, 142 хуулийн этгээдийг 1581.4 сая төгрөгөөр торгож, 405 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 14.4 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 110 буюу 21.4 хувиар буурсан байна.

---oooOooo---


2.2. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 45248 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 21566 буюу 47.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 23682 буюу 52.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 6265 буюу 12.2 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 14.9 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 9.0 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 5282 буюу 24.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 15044 буюу 69.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 348 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 6903 буюу 29.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 16427 буюу 69.4 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 78 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.



1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 8017 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 685 буюу 7.9 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 24.2 хувийг эзэлж байна.

1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 89.455 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 6.2%-тай байж, 2030 онд 10806 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	218	240	22	10.1	*23-р хороо*	180	125	-55	-30.6
2-р хороо	234	284	50	21.4	*24-р хороо*	94	87	-7	-7.4
3-р хороо	320	299	-21	-6.6	*25-р хороо*	182	229	47	25.8
4-р хороо	337	208	-129	-38.3	*26-р хороо*	453	416	-37	-8.2
5-р хороо	240	217	-23	-9.6	*27-р хороо*	157	240	83	52.9
6-р хороо	307	229	-78	-25.4	*28-р хороо*	91	86	-5	-5.5
7-р хороо	326	331	5	1.5	*29-р хороо*	89	88	-1	-1.1
8-р хороо	300	202	-98	-32.7	*30-р хороо*	305	132	-173	-56.7
9-р хороо	176	107	-69	-39.2	*31-р хороо*	92	111	19	20.7
10-р хороо	271	133	-138	-50.9	*32-р хороо*	92	105	13	14.1
11-р хороо	307	280	-27	-8.8	*33-р хороо*	55	49	-6	-10.9
12-р хороо	198	130	-68	-34.3	*34-р хороо*	94	63	-31	-33.0
13-р хороо	228	274	46	20.2	*35-р хороо*	64	50	-14	-21.9
14-р хороо	543	434	-109	-20.1	*36-р хороо*	139	170	31	22.3
15-р хороо	143	109	-34	-23.8	*37-р хороо*	132	95	-37	-28.0
16-р хороо	329	434	105	31.9	*38-р хороо*	160	136	-24	-15.0
17-р хороо	123	121	-2	-1.6	*39-р хороо*	147	93	-54	-36.7
18-р хороо	181	158	-23	-12.7	*40-р хороо*	93	112	19	20.4
19-р хороо	197	223	26	13.2	*41-р хороо*	100	105	5	5.0
20-р хороо	173	109	-64	-37.0	*42-р хороо*	326	509	183	56.1
21-р хороо	99	120	21	21.2	*43-р хороо*	145	148	3	2.1
22-р хороо	262	226	-36	-13.7					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 7107 буюу 88.6 хувь нь хөнгөн, 910 буюу 11.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 11.4 хувиар буурч, хүнд хэрэг 32.5 хувиар өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	186	192	3.2	2.4
	Үүнээс: Хүнийг алах	18	30	66.7	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	974	1282	31.6	16.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	147	111	-24.5	1.4
	Үүнээс: Хүчиндэх	104	83	-20.2	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	136	83	-39.0	1.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	4	-	-	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	11	5	-54.5	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	32	13	-59.4	0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	6592	5574	-15.4	69.5
	Үүнээс: Хулгайлах	1750	1386	-20.8	17.3
	Үүнээс: Дээрэмдэх	89	116	30.3	1.4
	Үүнээс: Залилах	4143	3453	-16.7	43.1
	Үүнээс: Малын хулгай	6	11	83.3	0.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг	58	42	-27.6	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	56	129	130.4	1.6
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	32	25	-21.9	0.3
13	Авлигын гэмт хэрэг	3	1	-66.7	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	25	24	-4.0	0.3
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	20	6	-70.0	0.1
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	133	148	11.3	1.8
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	292	377	29.1	4.7
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	5	-	0.1

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг,араг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1231 буюу 15.4 хувь нь Даваа гарагт, 1145 буюу 14.3 хувь нь Мягмар гарагт, 1190 буюу 14.8 хувь нь Лхагва гарагт, 1193 буюу 14.9 хувь нь Пүрэв гарагт, 1208 буюу 15.1 хувь нь Баасан гарагт, 1107 буюу 13.8 хувь нь Бямба гарагт, 943 буюу 11.7 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 3258 буюу 40.6 хувь нь 06:00-14:00 цагт, 2036 буюу 25.4 хувь нь 14:00-19:00 цагт, 897 буюу 11.2 хувь нь 19:00-22:00 цагт, 1826 буюу 22.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	**Нийт**
0:00	3	2	2	6	1	2	7	**23**
1:00	31	35	35	39	29	31	29	**229**
2:00	26	42	51	50	28	34	41	**272**
3:00	20	16	14	9	12	16	23	**110**
4:00	30	40	28	28	22	31	27	**206**
5:00	40	53	34	40	50	36	30	**283**
6:00	14	8	12	8	4	6	4	**56**
7:00	31	28	33	33	26	26	29	**206**
8:00	85	94	95	70	75	78	63	**560**
9:00	29	16	14	12	15	13	17	**116**
10:00	80	102	84	69	86	68	76	**565**
11:00	132	100	113	109	101	117	70	**742**
12:00	36	30	39	27	26	21	20	**199**
13:00	166	146	149	122	129	88	115	**915**
14:00	143	121	131	131	106	98	90	**820**
15:00	43	40	35	42	37	25	38	**260**
16:00	107	116	122	100	92	73	72	**682**
17:00	92	100	118	86	91	80	78	**645**
18:00	14	31	24	20	14	18	19	**140**
19:00	65	72	59	63	61	50	51	**421**
20:00	88	69	87	72	61	71	61	**509**
21:00	9	22	16	20	16	29	24	**136**
22:00	49	54	43	37	39	39	41	**302**
23:00	43	42	45	46	55	30	44	**305**
Нийт	**1376**	**1379**	**1383**	**1239**	**1176**	**1080**	**1069**	**8702**

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3566 буюу 44.5 хувь нь гэр орон сууцанд, 1528 буюу 19.1 хувь нь гудамж талбайд, 1089 буюу 13.6 хувь нь олон нийтийн газарт, 57 буюу 0.7 хувь нь нийтийн тээвэрт, 80 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 54 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 564 буюу 7.0 хувь нь аж ахуйн нэгжид, 384 буюу 4.8 хувь нь авто замд, 695 буюу 8.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 561 буюу 7.0 хувь нь согтуугаар, 621 буюу 7.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 195 буюу 2.4 хувь нь бүлэглэн, 214 буюу 2.7 хувь нь хүүхэд оролцож, 195 буюу 2.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 3244 буюу 40.5 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 18476 хэрэгт хэрэг бүртгэлт, 677 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 19153 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 7363 урьд оны үлдэгдэл хэрэг, 10656 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 33, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1101 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 12234 буюу 63.9 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-8535 буюу 69.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-1977 буюу 16.2 хувийг шүүхэд шилжүүлж;
-45 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож;
-1458 буюу 11.9 хувийг эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-219 буюу 1.8 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 63.9 хувь, хуулийн анхны хугацаанд 97.4 хувийг шийдвэрлэж 679 хүнд холбогдох 7326 хэргийн үлдэгдэлтэй байна.



2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 2924 буюу 36.5 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 43.5 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.4 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 0.2 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 7865 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 546 хэрэг буюу 6.5 хувиар, 3424 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 270 буюу 7.3 хувиар тус тус буурсан байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 3716 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 18.5 хувиар буурсан.

Яллагдагчдын 406 буюу 10.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 80.0 хувиар буурч, 3310 буюу 89.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 30.5 хувиар, 272 буюу 7.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 7.1 хувиар тус тус өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 7732 иргэн, 19 хуулийн этгээд хохирч, 196 хүн нас барж, 1445 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 786 буюу 9.2 хувиар буурч, хуулийн этгээд 4 буюу 26.7 хувиар, нас барсан хүн 60 буюу 44.1 хувиар тус тус өсөж, гэмтсэн хүн 290 буюу 25.1 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 106.1 тэрбум төгрөгийн хохирлын 49.5 тэрбум төгрөг буюу 46.7 хувийг нөхөн төлүүлж, 0.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх онтой харьцуулахад хохирлын хэмжээ 7.0 тэрбум төгрөг буюу 7.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 4.0 тэрбум төгрөг буюу 9.0 хувиар тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 36.8 сая төгрөг буюу 99.2 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 49015 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулахад 16092 буюу 48.9 хувиар, 47557 зөрчлийг шийдвэрлэсэн нь 14884 буюу 45.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 518 буюу 1.1 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 28879 буюу 58.9 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1863 буюу 3.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1121 буюу 2.3 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 16634 буюу 33.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 45984 иргэн, 268 хуулийн этгээдийг 2463.7 сая төгрөгөөр торгож, 1304 хүнийг баривчлуулах, 1 хүнийг сургалтад хамруулсан нь өмнөх онтой харьцуулахад иргэнийг торгосон шийтгэл 15600 буюу 51.3 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 712 буюу 35.3 хувиар буурсан байна.

Нийт 4424 хүн саатуулагдаж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 95 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад саатуулагдсан хүн 1227 буюу 38.4 хувиар өсөж, эрүүлжүүлэгдсэн хүн 40 буюу 72.7 хувиар буурсан байна.

---oooOooo---


2.3. СҮХБААТАР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 21159 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 11890 буюу 56.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 9269 буюу 43.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 2063 буюу 8.9 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 3.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 14.9 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2666 буюу 22.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 8376 буюу 70.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 268 буюу 2.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2808 буюу 30.3 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн, 6283 буюу 67.8 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзаж, 6 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.



1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 5196 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 738 буюу 16.6 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.7 хувийг эзэлж байна.

1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 55.131 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 7.6%-тай байж, 2030 онд 7497 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	1174	1475	301	25.6	*11-р хороо*	342	435	93	27.2
2-р хороо	105	114	9	8.6	*12-р хороо*	85	115	30	35.3
3-р хороо	384	364	-20	-5.2	*13-р хороо*	107	127	20	18.7
4-р хороо	125	139	14	11.2	*14-р хороо*	104	80	-24	-23.1
5-р хороо	100	112	12	12.0	*15-р хороо*	51	72	21	41.2
6-р хороо	265	353	88	33.2	*16-р хороо*	123	141	18	14.6
7-р хороо	184	223	39	21.2	*17-р хороо*	42	40	-2	-4.8
8-р хороо	619	614	-5	-0.8	*18-р хороо*	73	75	2	2.7
9-р хороо	215	347	132	61.4	*19-р хороо*	76	91	15	19.7
10-р хороо	206	210	4	1.9	*20-р хороо*	78	69	-9	-11.5

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4664 буюу 89.8 хувь нь хөнгөн, 532 буюу 10.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оноос хөнгөн хэрэг 14.2, хүнд хэрэг 42.6 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	83	50	-39.8	1.0
	Үүнээс: Хүнийг алах	9	11	22.2	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	801	876	9.4	16.9
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	45	43	-4.4	0.8
	Үүнээс: Хүчиндэх	31	32	3.2	0.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	84	127	51.2	2.4
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	3	-	-	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дахин	0.0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3035	3577	17.9	68.8
	Үүнээс: Хулгайлах	649	756	16.5	14.5
	Дээрэмдэх	67	81	20.9	1.6
	Залилах	1936	2332	20.5	44.9
	Малын хулгай	1	-	-	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг	55	40	-27.3	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	51	62	21.6	1.2
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	31	32	3.2	0.6
13	Авлигын гэмт хэрэг	4	3	-25.0	0.1
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	37	59	59.5	1.1
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	3	-	-	-
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дахин	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	65	71	9.2	1.4
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	155	249	60.6	4.8
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 813 буюу 15.6 хувь нь Даваа гарагт, 844 буюу 16.2 хувь нь Мягмар гарагт, 812 буюу 15.6 хувь нь Лхагва гарагт, 710 буюу 13.7 хувь нь Пүрэв гарагт, 771 буюу 14.8 хувь нь Баасан гарагт, 655 буюу 12.6 хувь нь Бямба гарагт, 591 буюу 11.5 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн

Цагаар нь авч үзвэл 2321 буюу 44.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1297 буюу 25.0 хувь нь 14:00-19:00 цагт, 353 буюу 6.8 хувь нь 19:00-22:00 цагт, 1225 буюу 23.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	**Нийт**
0:00	3			5	3	4	3	18
1:00	35	36	34	42	30	26	27	230
2:00	43	48	35	33	34	47	34	274
3:00	13	12	11	15	13	21	15	100
4:00	19	31	22	26	29	30	24	181
5:00	31	38	34	25	34	41	15	218
6:00	6	7	12	3	10	5	6	49
7:00	21	26	23	26	30	25	27	178
8:00	49	40	49	48	36	32	19	273
9:00	16	12	12	13	13	11	9	86
10:00	82	78	84	77	71	64	51	507
11:00	65	85	70	46	73	43	43	425
12:00	36	32	56	34	35	24	23	240
13:00	94	106	85	67	91	60	60	563
14:00	73	62	59	58	56	50	51	409
15:00	50	35	39	31	36	26	36	253
16:00	51	54	60	42	57	31	34	329
17:00	32	34	36	31	27	17	17	194
18:00	17	24	15	15	12	11	18	112
19:00	18	23	14	31	15	14	26	141
20:00	17	17	19	12	28	23	15	131
21:00	16	11	13	8	10	14	9	81
22:00	12	17	12	16	13	24	14	108
23:00	14	16	18	6	15	12	15	96
Нийт	813	844	812	710	771	655	591	5196

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 947 буюу 18.2 хувь нь гэр орон сууцанд, 1202 буюу 23.1 хувь нь гудамж талбайд, 612 буюу 11.8 хувь нь олон нийтийн газарт, 17 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 56 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 41 буюу 0.8 хувь нь төрийн бус байгууллагад, 772 буюу 14.9 хувь нь аж ахуйн нэгжид, 248 буюу 4.8 хувь нь авто замд, 1301 буюу 25.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 301 буюу 5.8 хувь нь согтуугаар, 547 буюу 10.5 хувь нь эмэгтэй хүн оролцож, 131 буюу 2.5 хувь нь бүлэглэн, 84 буюу 1.6 хувь нь хүүхэд оролцож, 79 буюу 1.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1543 буюу 29.7 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 8711 хэрэгт хэрэг бүртгэлт, 254 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 8965 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 3526 урьд оны үлдэгдэл хэрэг, 5218 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 19, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 202 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4776 буюу 53.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-2833 буюу 59.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-990 буюу 20.7 хувийг шүүхэд шилжүүлж;
-18 буюу 0.4 хувийг хэрэгсэхгүй болгож;
-759 буюу 16.1 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-166 буюу 3.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 53.3 хувь, хуулийн анхны хугацаанд 90.5 хувийг шийдвэрлэж 576 хүнд холбогдох 4459 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сүхбаатар дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1996 буюу 38.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 39.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 6.2 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 4.2 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 5124 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 934 хэрэг буюу 22.4 хувиар, 2025 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 110 буюу 5.7 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2253 хүн шалгагдсан нь өмнөх оноос 0.1 хувиар өссөн. Яллагдагчдын 1915 буюу 85.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оноос 1.0 хувиар, 124 буюу 5.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 39.8 хувиар тус тус буурч, 338 буюу 15.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 6.0 хувиар өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4961 иргэн, 21 хуулийн этгээд хохирч, 56 хүн нас барж, 1025 хүн гэмтсэн нь өмнөх оноос хохирсон хүн 646 буюу 15.0 хувиар, гэмтсэн хүн 123 буюу 13.6 хувиар тус тус өсөж, нас барсан хүн 11 буюу 16.4 хувиар буурсан.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 213.2 тэрбум төгрөгийн хохирлын 30.1 тэрбум төгрөг буюу 14.1 хувийг нөхөн төлүүлж, 16.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 49.5 тэрбум төгрөг буюу 30.3 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 1030.9 сая төгрөг буюу 3.3 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 2525.9 сая төгрөг буюу 99.4 хувиар тус тус буурсан байна.

Тав. Зөрчил.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 39274 зөрчил шалгасан нь өмнөх оноос 41.9 хувиар, 38529 зөрчлийг шийдвэрлэсэн нь 42.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 27426 буюу 69.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 6944 буюу 17.7 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 798 буюу 2.0 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 201 буюу 0.5 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 3905 буюу 9.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 37984 иргэн, 112 хуулийн этгээдийг 1357.7 сая төгрөгөөр торгож, 431 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 44.6 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 28.6 хувиар буурсан байна.

2025 онд Сүхбаатар дүүрэгт нийт 11 хүн саатуулсан нь өмнөх оноос 1 буюу 8.3 хувиар буурсан байна.

---oooOooo---

2.4. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 36235 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 15001 буюу 41.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 21234 буюу 58.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 6343 буюу 17.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 6219 буюу 22.6 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 124 буюу 0.8 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 3696 буюу 24.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 10523 буюу 70.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 139 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 7897 буюу 37.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 13021 буюу 61.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 15 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 5182 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1284 буюу 32.9 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 15.6 хувийг эзэлж байна.



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 57.853 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 5.3%-тай байж, 2030 онд 6.700 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	64	87	23	35.9	*23-р хороо*	47	94	47	2.0 дах
2-р хороо	83	94	11	13.3	*24-р хороо*	105	147	42	40.0
3-р хороо	67	68	1	1.5	*25-р хороо*	77	88	11	14.3
4-р хороо	80	113	33	41.3	*26-р хороо*	73	83	10	13.7
5-р хороо	64	64	0	0.0	*27-р хороо*	122	196	74	60.7
6-р хороо	103	132	29	28.2	*28-р хороо*	80	63	-17	-21.3
7-р хороо	95	149	54	56.8	*29-р хороо*	188	250	62	33.0
8-р хороо	77	107	30	39.0	*30-р хороо*	39	51	12	30.8
9-р хороо	99	131	32	32.3	*31-р хороо*	54	55	1	1.9
10-р хороо	89	234	145	2.6 дах	*32-р хороо*	195	260	65	33.3
11-р хороо	93	108	15	16.1	*33-р хороо*	149	192	43	28.9
12-р хороо	144	255	111	77.1	*34-р хороо*	83	123	40	48.2
13-р хороо	65	122	57	87.7	*35-р хороо*	22	29	7	31.8
14-р хороо	113	118	5	4.4	*36-р хороо*	77	74	-3	-3.9
15-р хороо	71	105	34	47.9	*37-р хороо*	204	142	-62	-30.4
16-р хороо	77	152	75	97.4	*38-р хороо*	53	81	28	52.8
17-р хороо	102	124	22	21.6	*39-р хороо*	24	55	31	2.3 дах
18-р хороо	104	151	47	45.2	*40-р хороо*	73	52	-21	-28.8
19-р хороо	183	224	41	22.4	*41-р хороо*	62	69	7	11.3
20-р хороо	155	227	72	46.5	*42-р хороо*	39	42	3	7.7
21-р хороо	93	139	46	49.5	*43-р хороо*	31	30	-1	-3.2
22-р хороо	80	102	22	27.5					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4470 буюу 86.3 хувь нь хөнгөн, 712 буюу 13.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 33.6, хүнд хэрэг 29.0 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	107	114	6.5	2.2
	Үүнээс: Хүнийг алах	24	14	-41.7	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	967	999	3.3	19.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	92	110	19.6	2.1
	Үүнээс: Хүчиндэх	73	88	20.5	1.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	36	36	0.0	0.7
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2329	3382	45.2	65.3
	Үүнээс: Хулгайлах	730	812	11.2	15.7
	Үүнээс: Дээрэмдэх	126	169	34.1	3.3
	Үүнээс: Залилах	1122	2080	85.4	40.1
	Үүнээс: Малын хулгай	11	12	9.1	0.2
9	Эдийн засгийн гэмт хэрэг	16	16	0.0	0.3
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	39	102	161.5	2.0
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.1
13	Авлигын гэмт хэрэг	-	-	-	-
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	16	21	31.3	0.4
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	17	17	0.0	0.3
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	39	41	5.1	0.8
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	226	330	46.0	6.4
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	3	-	0.1

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг,араг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 865 буюу 16.7 хувь нь Даваа гарагт, 831 буюу 16.0 хувь нь Мягмар гарагт, 762 буюу 14.7 хувь нь Лхагва гарагт, 779 буюу 15.0 хувь нь Пүрэв гарагт, 741 буюу 14.3 хувь нь Баасан гарагт, 588 буюу 11.3 хувь нь Бямба гарагт, 616 буюу 11.9 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1956 буюу 37.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1402 буюу 27.1 хувь нь 14:00-19:00 цагт, 751 буюу 14.5 хувь нь 19:00-22:00 цагт, 1073 буюу 20.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
00:00	5	6	6	3	3	3	2	28
01:00	14	18	23	21	25	18	22	141
02:00	20	25	22	19	27	15	20	148
03:00	6	14	13	9	9	13	10	74
04:00	14	13	13	11	18	8	21	98
05:00	32	21	27	22	23	30	25	180
06:00	5	3	3	7	7	8	9	42
07:00	24	24	15	18	17	8	23	129
08:00	44	49	42	66	38	18	30	287
09:00	12	15	10	12	14	14	9	86
10:00	85	75	74	67	64	47	50	462
11:00	67	55	71	70	52	43	50	408
12:00	14	23	17	19	14	8	21	116
13:00	83	67	59	71	58	49	39	426
14:00	76	65	68	58	61	52	56	436
15:00	22	12	15	8	18	14	13	102
16:00	67	81	55	47	50	56	28	384
17:00	78	58	60	56	68	34	39	393
18:00	15	14	8	12	13	10	15	87
19:00	48	49	46	36	44	37	37	297
20:00	60	61	53	67	56	46	40	383
21:00	12	6	6	15	12	7	13	71
22:00	22	31	28	29	18	16	17	161
23:00	40	46	28	36	32	34	27	243
Нийт	865	831	762	779	741	588	616	5182

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1994 буюу 38.5 хувь нь гэр орон сууцанд, 1108 буюу 21.4 хувь нь гудамж талбайд, 375 буюу 7.2 хувь нь олон нийтийн газарт, 43 буюу 0.8 хувь нь нийтийн тээвэрт, 21 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 11 буюу 0.2 хувь нь төрийн бус байгууллагад, 450 буюу 8.7 хувь нь аж ахуйн нэгжид, 328 буюу 6.3 хувь нь авто замд, 852 буюу 16.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 301 буюу 5.8 хувь нь согтуугаар, 498 буюу 9.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 175 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 140 буюу 2.7 хувь нь хүүхэд оролцож, 117 буюу 2.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1735 буюу 33.5 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 9735 хэрэгт хэрэг бүртгэлт, 605 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 10340 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 3372 урьд оны үлдэгдэл хэрэг, 6552 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 11, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 405 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 6387 буюу 61.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-3862 буюу 60.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-1553 буюу 24.3 хувийг шүүхэд шилжүүлж;
-34 буюу 0.5 хувийг хэрэгсэхгүй болгож;
-895 буюу 14.0 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-43 буюу 0.7 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 61.8 хувь, хуулийн анхны хугацаанд 98.3 хувийг шийдвэрлэж 346 хүнд холбогдох 4051 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 2466 буюу 47.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 48.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.1 нэгжээр өсөж. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 5.0 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 5030 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 35.7 хувиар өсөж, 2452 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 41.8 хувиар өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2743 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 38.9 хувиар. Яллагдагчдын 2380 буюу 86.8 хувь нь эрэгтэй хүн эзэлж байгаа нь 52.8 хувиар, 201 буюу 7.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 12.9 хувиар тус тус өсөж, 363 буюу 13.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 12.9 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4933 иргэн, 22 хуулийн этгээд хохирч, 142 хүн нас барж, 1151 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 1113 буюу 29.1 хувиар, нас барсан хүн 30 буюу 26.8 хувиар тус тус өссөн.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 55.1 тэрбум төгрөгийн хохирлын 14.1 тэрбум төгрөг буюу 25.7 хувийг нөхөн төлүүлж, 93.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 37.6 тэрбум төгрөг буюу 3.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 7.3 тэрбум төгрөг буюу 2.1 дахин тус тус өсөж, битүүмжилсэн хөрөнгө 105.1 сая төгрөг буюу 52.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 56914 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 10.9 хувиар, 55734 зөрчлийг шийдвэрлэсэн нь 10.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18676 буюу 32.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 28435 буюу 50.0 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1846 буюу 3.2 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 670 буюу 1.2 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 7287 буюу 12.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 54.264 иргэн, 179 хуулийн этгээдийг 1858.2 сая төгрөгөөр торгож, 1291 хүнийг баривчлуулах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 10.7 хувиар, хуулийн этгээд 5.8 дахин тус тус өсөж, баривчлуулсан шийтгэл 19.5 хувиар буурсан байна.

2025 онд Сонгинохайрхан дүүрэгт нийт 1680 хүн согтууруулах үндаа хэтрүүлэн хэрэглэн эрүүлжүүлэгдэж, 6850 хүн саатуулсан нь өмнөх оноос эрүүлжүүлсэн хүн 899 буюу 2.2 дахин, саатуулсан хүн 187 буюу 2.8 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---

2.5. ХАН-УУЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Хан-Уул дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 24789 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 12578 буюу 50.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 12211 буюу 49.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 0.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 9.2 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 9.4 хувиар өссөн байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 4298 буюу 34.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 7445 буюу 59.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 273 буюу 2.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 4423 буюу 36.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 7591 буюу 62.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 47 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 5465 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 364 буюу 7.1 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 16.5 хувийг эзэлж байна.



1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 40.470 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 11.1%-тай байж, 2030 онд 9.000 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	241	165	-76	-31.5	*14-р хороо*	96	116	20	20.8
2-р хороо	238	205	-33	-13.9	*15-р хороо*	652	646	-6	-0.9
3-р хороо	415	391	-24	-5.8	*16-р хороо*	106	86	-20	-18.9
4-р хороо	183	282	99	54.1	*17-р хороо*	236	303	67	28.4
5-р хороо	73	91	18	24.7	*18-р хороо*	263	279	16	6.1
6-р хороо	83	98	15	18.1	*19-р хороо*	224	237	13	5.8
7-р хороо	31	44	13	41.9	*20-р хороо*	574	475	-99	-17.2
8-р хороо	150	171	21	14.0	*21-р хороо*	238	315	77	32.4
9-р хороо	67	84	17	25.4	*22-р хороо*	69	80	11	15.9
10-р хороо	120	127	7	5.8	*23-р хороо*	216	293	77	35.6
11-р хороо	370	408	38	10.3	*24-р хороо*	237	293	56	23.6
12-р хороо	58	77	19	32.8	*25-р хороо*	118	155	37	31.4
13-р хороо	43	44	1	2.3					

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4932 буюу 90.2 хувь нь хөнгөн, 533 буюу 9.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 5.2 хувиар, хүнд хэрэг 29.4 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл		Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
			2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		75	62	-17.3	1.1
	Үүнээс: Хүнийг алах		14	15	7.1	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		614	750	22.1	13.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		53	65	22.6	1.2
	Үүнээс: Хүчиндэх		44	57	29.5	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		81	94	16.0	1.7
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг		2	1	-50.0	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		8	7	-12.5	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		5	4	-20.0	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		3884	3965	2.1	72.6
	Үүнээс:	Хулгайлах	996	1081	8.5	19.8
		Дээрэмдэх	40	55	37.5	1.0
		Залилах	2370	2206	-6.9	40.4
		Малын хулгай	3	8	2.7 дахи	0.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг		42	31	-26.2	0.6
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		-	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		34	80	2.4 дахин	1.5
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		18	36	2.0 дахин	0.7
13	Авлигын гэмт хэрэг		1	-	-	-
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		25	24	-4.0	0.4
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг		18	2	-88.9	0.0
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг			1	-	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		55	63	14.5	1.2
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг		186	280	50.5	5.1

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 820 буюу 15.0 хувь нь Даваа гарагт, 811 буюу 14.8 хувь нь Мягмар гарагт, 802 буюу 14.8 хувь нь Лхагва гарагт, 817 буюу 14.9 хувь нь Пүрэв гарагт, 830 буюу 15.2 хувь нь Баасан гарагт, 694 буюу 12.7 хувь нь Бямба гарагт, 691 буюу 12.6 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2224 буюу 40.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1517 буюу 27.8 хувь нь 14:00-19:00 цагт, 541 буюу 9.9 хувь нь 19:00-22:00 цагт, 1183 буюу 21.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
0:00	4	1	3	5	5	5	6	**29**
1:00	14	19	17	21	25	29	29	**154**
2:00	26	27	32	23	27	20	29	**184**
3:00	9	9	10	16	10	21	15	**90**
4:00	20	15	24	13	12	10	19	**113**
5:00	21	19	18	25	17	14	16	**130**
6:00	7	9	7	8	6	8	6	**51**
7:00	23	17	20	16	9	12	13	**110**
8:00	29	28	26	42	30	28	27	**210**
9:00	13	16	16	14	14	11	14	**98**
10:00	76	77	101	110	96	68	56	**584**
11:00	54	68	64	56	74	52	50	**418**
12:00	23	22	26	26	26	25	30	**178**
13:00	120	94	81	76	80	59	65	**575**
14:00	77	69	69	78	79	57	59	**488**
15:00	35	40	25	32	28	29	21	**210**
16:00	58	63	65	50	73	48	49	**406**
17:00	45	48	40	47	49	33	32	**294**
18:00	20	20	15	15	14	14	21	**119**
19:00	37	26	29	30	36	28	37	**223**
20:00	34	38	28	42	34	32	26	**234**
21:00	11	16	17	11	8	13	8	**84**
22:00	26	25	29	18	27	37	20	**182**
23:00	38	45	40	43	51	41	43	**301**
Нийт	**820**	**811**	**802**	**817**	**830**	**694**	**691**	**5465**

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 2079 буюу 38.0 хувь нь гэр орон сууцанд, 963 буюу 17.7 хувь нь гудамж талбайд, 412 буюу 7.6 хувь нь олон нийтийн газарт, 23 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 23 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 22 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 531 буюу 9.7 хувь нь аж ахуйн нэгжид, 303 буюу 5.5 хувь нь авто замд, 1109 буюу 20.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 351 буюу 6.4 хувь нь согтуугаар, 722 буюу 13.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 148 буюу 2.7 хувь нь бүлэглэн, 88 буюу 1.6 хувь нь хүүхэд оролцож, 124 буюу 2.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1772 буюу 32.4 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 11970 хэрэгт хэрэг бүртгэлт, 243 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 12213 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 5228 урьд оны үлдэгдэл хэрэг, 6383 тухайн оны дугаартай хэрэг, 41 урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 561 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 7266 буюу 59.5 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-5109 буюу 70.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-1316 буюу 18.1 хувийг шүүхэд шилжүүлж;
-24 буюу 0.3 хувийг хэрэгсэхгүй болгож;
-645 буюу 8.9 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-172 буюу 2.4 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 59.5 хувь, хуулийн анхны хугацаанд 98.4 хувийг шийдвэрлэж, 291 хүнд холбогдох 5059 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хан-Уул нийт бүртгэгдсэн хэргийн 2132 буюу 39.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 34.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.3 нэгжээр өссөн. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 9.0 нэгжээр бага байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 5316 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 444 хэрэг буюу 9.1 хувиар өсөж, 1843 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 168 буюу 10.0 хувиар өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2121 хүн шалгагдсан нь өмнөх оноос 2.9 хувиар өссөн. Яллагдагчдын 1640 буюу 77.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 6.2 хувиар, 99 буюу 4.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 65.3 хувиар тус тус буурч, 481 буюу 22.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 53.2 хувиар өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 5219 иргэн, 14 хуулийн этгээд хохирч, 72 хүн нас барж, 859 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 220 буюу 4.4 хувиар, гэмтсэн хүн 113 буюу 15.1 хувиар тус тус өсөж, нас барсан хүн 8 буюу 10.0 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




/Сая төгрөгөөр/

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 190.4 тэрбум төгрөгийн хохирлын 99.3 тэрбум төгрөг буюу 52.1 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 61.6 тэрбум төгрөг буюу 47.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 12.9 тэрбум төгрөг буюу 15.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 82.3 сая төгрөг буюу 3.8 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 22079 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 24.7 хувиар, 21487 зөрчлийг шийдвэрлэсэн нь 25.0 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 8345 буюу 37.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 7934 буюу 35.9 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 137 буюу 0.6 хувь нь Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1019 буюу 4.6 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 4644 буюу 21.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 20730 иргэн, 177 хуулийн этгээдийг 1002.6 сая төгрөгөөр торгож, 580 хүнийг баривчлуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 26.2 хувиар өсөж, баривчлуулсан шийтгэл 6.5 хувиар буурсан байна.

2025 онд Хан-Уул дүүрэгт нийт 3267 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оноос 664 буюу 25.5 хувиар өссөн бол согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн эрүүлжүүлэгдсэн хүн 485 бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 289 буюу 2.5 дахин тус тус өссөн байна.

---oooOooo---

2.6. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.


Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 16.841 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 7904 буюу 46.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 8937 буюу 53.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна.

Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 2885 буюу 14.6 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 517 буюу 6.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2368 буюу 20.9 хувиар тус тус буурсан байна.


Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2812 буюу 35.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4627 буюу 58.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 124 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 5277 буюу 59.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 3473 буюу 38.9 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 44 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.



1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 3801 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 432 буюу 12.8 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 11.5 хувийг эзэлж байна.

1.3. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 42.762 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 7.5%-тай байж, 2030 онд 5451 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.4. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*		*Хороо*	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь				Тоо	Хувь
1-р хороо	273	265	-8	-2.9	*13-р хороо*	286	184	-102	-35.7
2-р хороо	270	292	22	8.1	*14-р хороо*	94	146	52	55.3
3-р хороо	277	275	-2	-0.7	*15-р хороо*	103	123	20	19.4
4-р хороо	244	200	-44	-18.0	*16-р хороо*	101	113	12	11.9
5-р хороо	378	429	51	13.5	*17-р хороо*	70	117	47	67.1
6-р хороо	175	176	1	0.6	*18-р хороо*	130	78	-52	-40.0
7-р хороо	95	154	59	62.1	*19-р хороо*	106	115	9	8.5
8-р хороо	61	110	49	80.3	*20-р хороо*	26	123	97	4.7 дах
9-р хороо	61	111	50	82.0	*21-р хороо*	53	53	0	0.0
10-р хороо	126	94	-32	-25.4	*22-р хороо*	37	40	3	8.1
11-р хороо	115	156	41	35.7	*23-р хороо*	26	24	-2	-7.7
12-р хороо	145	334	189	2.3 дах	*24-р хороо*	117	88	-29	-24.8
					28-р хороо		1	1	

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3377 буюу 88.8 хувь нь хөнгөн, 424 буюу 11.2 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 11.2 хувиар, хүнд хэрэг 2.9 хувиар тус тус өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	66	56	-15.2	1.5
	Үүнээс: Хүнийг алах	14	9	-35.7	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	621	559	-10.0	14.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	51	58	13.7	1.5
	Үүнээс: Хүчиндэх	43	39	-9.3	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	36	34	-5.6	0.9
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дахин	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2266	2549	12.5	67.1
	Үүнээс: Хулгайлах	613	525	-14.4	13.8
	Үүнээс: Дээрэмдэх	38	63	65.8	1.7
	Үүнээс: Залилах	1368	1708	24.9	44.9
	Үүнээс: Малын хулгай	-	-	-	-
9	Эдийн засгийн гэмт хэрэг	36	30	-16.7	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	-	-	-
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	59	66	11.9	1.7
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	12	16	33.3	0.4
13	Авлигын гэмт хэрэг	1	-	-	-
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	18	26	44.4	0.7
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	7	7	0.0	0.2
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	14	6	-57.1	0.2
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	26	212	8.2 дахин	5.6
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	152	178	17.1	4.7
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг,араг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 578 буюу 15.2 хувь нь Даваа гарагт, 569 буюу 15.0 хувь нь Мягмар гарагт, 611 буюу 16.1 хувь нь Лхагва гарагт, 558 буюу 14.7 хувь нь Пүрэв гарагт, 509 буюу 13.4 хувь нь Баасан гарагт, 479 буюу 12.6 хувь нь Бямба гарагт, 497 буюу 13.1 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1674 буюу 44.0 хувь нь 06:00-14:00 цагт, 1074 буюу 28.3 хувь нь 14:00-19:00 цагт, 357 буюу 9.4 хувь нь 19:00-22:00 цагт, 696 буюу 18.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
0:00	3	3	3	1	3	2	2	17
1:00	9	10	12	14	11	10	18	84
2:00	13	18	17	8	9	17	7	89
3:00	4	10	14	5	5	9	4	51
4:00	23	20	19	16	16	19	23	136
5:00	19	23	17	18	12	21	12	122
6:00		6	6	6	6	8	5	37
7:00	19	11	17	17	13	17	11	105
8:00	28	24	27	22	28	23	21	173
9:00	9	15	13	10	15	11	4	77
10:00	56	52	65	38	33	47	64	355
11:00	28	38	36	39	25	20	39	225
12:00	41	43	55	45	35	42	34	295
13:00	66	59	64	69	50	47	52	407
14:00	52	47	54	50	35	37	33	308
15:00	22	16	16	11	19	8	21	113
16:00	43	40	52	58	46	28	50	317
17:00	42	38	37	46	39	38	23	263
18:00	7	10	11	9	14	10	12	73
19:00	29	26	13	20	25	7	18	138
20:00	23	20	25	17	30	27	20	162
21:00	11	8	9	4	10	7	8	57
22:00	16	17	10	15	14	16	10	98
23:00	15	15	19	20	16	8	6	99
Нийт	578	569	611	558	509	479	497	3801

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1211 буюу 31.9 хувь нь гэр орон сууцанд, 537 буюу 14.1 хувь нь гудамж талбайд, 539 буюу 14.2 хувь нь олон нийтийн газарт, 17 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 33 буюу 0.9 хувь нь төрийн байгууллагад, 23 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 352 буюу 9.3 хувь нь аж ахуйн нэгжид, 187 буюу 4.9 хувь нь авто замд, 902 буюу 23.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 287 буюу 7.5 хувь нь согтуугаар, 379 буюу 10.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 109 буюу 2.9 хувь нь бүлэглэн, 91 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 101 буюу 2.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1723 буюу 45.3 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.




1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 6439 хэрэгт хэрэг бүртгэлт, 263 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 6702 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 2109 урьд оны үлдэгдэл хэрэг, 4331 тухайн оны дугаартай хэрэг, 29 урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 233 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4568 буюу 68.2 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-2511 буюу 55.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-865 буюу 18.9 хувийг шүүхэд шилжүүлж;
-30 буюу 0.7 хувийг хэрэгсэхгүй болгож;
-1006 буюу 22.0 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-156 буюу 3.4 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 68.2 хувь, хуулийн анхны хугацаанд 94.1 хувийг шийдвэрлэж, 168 хүнд холбогдох 221 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Чингэлтэй дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1437 буюу 37.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 51.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.1 нэгжээр буурсан. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 8.1 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 3711 хэрэг нээн шалгасан нь өмнөх оноос 508 хэрэг буюу 15.9 хувиар өсөж, 1924 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 263 буюу 15.8 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 2120 хүн шалгагдсан нь өмнөх оноос 9.2 хувиар өссөн. Яллагдагчдын 1883 буюу 88.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 26.0 хувиар өсөж, 118 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 29.7 хувиар тус тус өсөж, 237 буюу 11.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 47.0 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3576 иргэн, 12 хуулийн этгээд хохирч, 61 хүн нас барж, 635 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал хохирсон хүн 346 буюу 10.7 хувиар, нас барсан хүн 11 буюу 22.0 хувиар тус тус өсөж, гэмтсэн хүн 82 буюу 11.4 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 79.2 тэрбум төгрөгийн хохирлын 19.5 тэрбум төгрөг буюу 24.7 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 54.3 тэрбум төгрөг буюу 40.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 35.6 тэрбум төгрөг буюу 64.6 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 45.4 сая буюу 2.2 дахин өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 31704 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 31.5 хувиар, 30734 зөрчлийг шийдвэрлэсэн нь 29.4 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 7031 буюу 22.2 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 16681 буюу 52.6 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 387 буюу 1.2 хувь нь Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1438 буюу 4.5 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 6167 буюу 19.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 29769 иргэн, 119 хуулийн этгээдийг 1064.6 сая төгрөгөөр торгож, 846 хүнийг баривчлуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 28.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 47.9 хувиар тус тус өссөн байна.

2.7. БАГАНУУР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 2508 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 652 буюу 26.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1856 буюу 74.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 150 буюу 6.4 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 11.2 хувиар тус тус өсөж, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 5.4 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 304 буюу 46.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 302 буюу 46.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 9 буюу 1.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1680 буюу 90.5 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдэж, 88 буюу 4.7 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 52 буюу 2.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 374 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 88 буюу 30.8 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.1 хувийг эзэлж байна.




1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Д/д	Хороо	2024 он	2025 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	107	118	11	10.3
2	2-р хороо	7	13	6	85.7
3	3-р хороо	67	100	33	49.3
4	4-р хороо	50	70	20	40.0
5	5-р хороо	55	73	18	32.7

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 255 буюу 68.2 хувь нь хөнгөн, 119 буюу 31.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 4.9 хувиар, хүнд хэрэг 2.8 дахин тус тус өссөн байна.

1.5. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 4.999 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 1.4%-тай байж, 2030 онд 400 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл		Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
			2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг		6	6	0	1.6
	Үүнээс: Хүнийг алах		5	2	-60	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		105	130	23.8	34.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг		7	19	2.7 дахин	5.1
	Үүнээс: Хүчиндэх		6	12	2.0 дахин	3.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		-	2	-	0.5
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг		132	125	-5.3	33.4
	Үүнээс:	Хулгайлах	44	58	31.8	15.5
		Дээрэмдэх	-	5	-	1.3
		Залилах	59	45	-23.7	12.0
		Малын хулгай	1	3	3.0 дахин	0.8

6	Эдийн засгийн гэмт хэрэг	6	1	-83.3	0.3
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	2	-60.0	0.5
8	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	-	1	-	0.3
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дахин	0.5
10	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.3
11	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4	7	75.0	1.9
12	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	19	78	4.1 дахин	20.9

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 59 буюу 15.8 хувь нь Даваа гарагт, 51 буюу 13.6 хувь нь Мягмар гарагт, 50 буюу 13.4 хувь нь Лхагва гарагт, 55 буюу 14.7 хувь нь Пүрэв гарагт, 54 буюу 14.4 хувь нь Баасан гарагт, 49 буюу 13.1 хувь нь Бямба гарагт, 56 буюу 15.0 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 94 буюу 25.1 хувь нь 06:00-14:00 цагт, 78 буюу 20.9 хувь нь 14:00-19:00 цагт, 56 буюу 15.0 хувь нь 19:00-22:00 цагт, 146 буюу 39.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	**Нийт**
0:00		2	2	1		2		7
1:00	7	5	1	4	3	5	5	30
2:00	2	6	2	2	3	5	6	26
3:00		2	1	5	2	5	1	16
4:00	6	1	1		3		2	13
5:00		1	2	1				4
6:00			1	2		1	1	5
7:00	2	2	1	3	1			9
8:00	2	3		4	1		2	12
9:00	2	1		1	2	1	1	8
10:00	3	2	3	2	3	2	3	18
11:00	4	1	1	1	2	2	2	13
12:00		2		3	2		1	8
13:00		5	5	2	3	1	5	21
14:00	3		5	4	6	3	1	22
15:00	4	3	3	1		1	2	14
16:00	5		1	1	2		3	12
17:00	1	3		1	2	4	1	12
18:00	1	1	3	4	2	2	5	18
19:00	3	1	4	1	3	2	2	16
20:00	5	2	2	3	3	3	5	23
21:00	1	2	1	3	3	3	4	17
22:00	2	3	6	3	5	3	2	24
23:00	6	3	5	3	3	4	2	26
Нийт	59	51	50	55	54	49	56	374

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 135 буюу 36.1 хувь нь гэр орон сууцанд, 69 буюу 18.4 хувь нь гудамж талбайд, 32 буюу 8.6 хувь нь олон нийтийн газарт, 5 буюу 1.3 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 28 буюу 7.5 хувь нь аж ахуйн нэгжид, 38 буюу 10.2 хувь нь авто замд, 66 буюу 17.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 175 буюу 46.8 хувь нь согтуугаар, 50 буюу 13.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 16 буюу 4.3 хувь нь бүлэглэн, 18 буюу 4.8 хувь нь хүүхэд оролцож, 25 буюу 6.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 46 буюу 12.3 хувь нь цахим орчинд тус тус үйлдэгдсэн байна.



1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 545 хэрэгт хэрэг бүртгэлт, 49 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 594 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 150 урьд оны үлдэгдэл хэрэг, 426 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 18 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 424 буюу 71.4 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

-139 буюу 32.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж;
-234 буюу 55.2 хувийг шүүхэд шилжүүлж;
-8 буюу 1.8 хувийг хэрэгсэхгүй болгож;
-33 буюу 7.8 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн;
-10 буюу 2.4 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 71.4 хувь, хуулийн анхны хугацаанд 90.8 хувийг шийдвэрлэж, 11 хүнд холбогдох 188 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Багануур дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 96 буюу 25.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 63.8 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.7 нэгжээр өссөн. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 20.1 нэгжээр их байна.

Сүүлийн 15 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 329 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 71 хэрэг буюу 27.5 хувиар, 210 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 47 буюу 28.8 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.

3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 289 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 29.6 хувиар өссөн. Яллагдагчдын 252 буюу 87.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 34.0 хувиар, 37 буюу 12.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 5.7 хувиар, 34 буюу 11.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 9.7 хувиар тус тус өссөн байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 315 иргэн, 5 хуулийн этгээд хохирч, 10 хүн нас барж, 146 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 43 буюу 15.8 хувиар, нас барсан хүн 4 буюу 66.7 хувиар, гэмтсэн хүн 31 буюу 27.0 хувиар, хуулийн этгээд 4 буюу 5.0 дахин тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1022.5 сая төгрөгийн хохирлын 308.6 сая төгрөг буюу 30.2 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос учирсан хохирол 304.3 сая төгрөг буюу 42.4 хувиар өсөж, нөхөн төлүүлсэн хохирол 2.8 сая төгрөг буюу 0.9 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 33205 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 9.2 хувиар, 33133 зөрчлийг шийдвэрлэсэн нь 9.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 31369 буюу 94.5 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 594 буюу 1.8 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 122 буюу 0.4 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 45 буюу 0.1 хувийг Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1075 буюу 3.2 бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 32528 иргэн, 16 хуулийн этгээдийг 1457.5 сая төгрөгөөр торгож, 109 хүнийг баривчлуулах, 447 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 27 хүнийг баривчилж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 6 хүнийг сургалтад хамруулж шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 9.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 8.4 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 36.3 хувиар өссөн байна.

2025 онд Баганууp дүүрэгт нийт 258 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 118 буюу 84.3 хувиар, 447 хүнийг саатуулсан нь өмнөх оноос 71 буюу 18.9 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---

2.8. БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 457 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 106 буюу 23.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 351 буюу 76.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 28 буюу 5.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 8.1 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2.9 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 51 буюу 48.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 49 буюу 46.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 1 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 321 буюу 91.5 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдсэн, 29 буюу 8.3 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзаж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 30 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 10 буюу 50.0 хувиар өссөн байна. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.1 хувийг эзэлж байна.


1.2.1. Бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүрэг).



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	*2024 он*	*2025 он*	*Өсөлт, бууралт*	
			Тоо	Хувь
1-р хороо	9	9	0	0
2-р хороо	11	21	10	90.9

1.4. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 426 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 1.5%-тай байж, 2030 онд 32 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 15 буюу 50.0 хувь нь хөнгөн, 15 буюу 50.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 6.3 хувиар буурч, хүнд хэрэг 3.7 дахин өссөн байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).


Д/д	*Гэмт хэргийн төрөл*	*Бүртгэгдсэн хэрэг*		*Өсөлт, бууралтын хувь*	*Нийт гэмт хэрэгт эзлэх хувь*
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	3.3
	Үүнээс: Хүнийг алах	-	1	-	3.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	11	37.5	36.7
3	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	5	66.7	16.7
	Хулгайлах	3	4	33.3	13.3
	Малын хулгай	-	1	-	3.3
4	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
5	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
6	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	6	13	2.2 дахин	43.3

1.7. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 3 буюу 10.0 хувь нь Даваа гарагт, 8 буюу 26.7 хувь нь Мягмар гарагт, 2 буюу 6.7 хувь нь Лхагва гарагт, 1 буюу 3.3 хувь нь Пүрэв гарагт, 5 буюу 16.7 хувь нь Баасан гарагт, 7 буюу 23.3 хувь нь Бямба гарагт, 4 буюу 13.3 хувь нь Ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 4 буюу 13.3 хувь нь 06:00-14:00 цагт, 5 буюу 16.7 хувь нь 14:00-19:00 цагт, 11 буюу 36.7 хувь нь 19:00-22:00 цагт, 10 буюу 33.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт
1:00		1			1	1	1	4
2:00		1	1					2
4:00						1		1
5:00		1						1
9:00						1		1
11:00					1			1
13:00						2		2
14:00	1							1
17:00		1						1
18:00		2	1					3
19:00	2			1		1		4
20:00		1			1			2
21:00		1			1		3	5
22:00					1	1		2
Нийт	3	8	2	1	5	7	4	30

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 12 буюу 40.0 хувь нь гэр орон сууцанд, 8 буюу 26.7 хувь нь гудамж талбайд, 6 буюу 20.0 хувь нь авто замд, 4 буюу 13.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.8. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 27 буюу 90.0 хувь нь согтуугаар, 6 буюу 20.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 3 буюу 10.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас түс түс үйлдэгдсэн байна.



1.9. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2025 онд 35 хэрэгт хэрэг бүртгэлт, 22 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 57 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 9 урьд оны үлдэгдэл хэрэг, 47 тухайн оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 1 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 48 буюу 84.2 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-11 буюу 22.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,

-31 буюу 64.6 хувийг шүүхэд шилжүүлж,

-1 буюу 2.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэгт нэгтгэж,

-4 буюу 8.3 хувийг нэгтгэж,

-1 буюу 2.1 хувийг хэрэгсэхгүй болгож, нийт шалгасан хэргийн 84.2 хувь, хуулийн анхны хугацаанд 100.0 хувь шийдвэрлэж, 3 хүнд холбогдох 13 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Багахангай дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 7 буюу 23.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 100.0 хувьтай байгаа нь өмнөх онтой ижил түвшинд байна. Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 56.3 нэгжээр их байна.

Сүүлийн 10 жилд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 11 хэрэг нээн шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 7 хэрэг буюу 2.8 дахин, 11 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 7 буюу 2.7 дахин тус тус өссөн байна.


Гурав. Яллагдагч.


3.1. Гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан хүн.

Нийт 37 хүн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 54.2 хувиар өссөн.

Яллагдагчдын 31 буюу 83.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 47.6 хувиар, 6 буюу 16.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 2.0 дахин тус тус өсөж, 1 буюу 2.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 75.0 хувиар буурсан байна.

3.2. Яллагдагчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 21 иргэн хохирч, 11 хүн гэмтсэн нь өмнөх онтой харьцуулбал, хохирсон хүн 2 буюу 10.5 хувь, гэмтсэн хүн 1 буюу 10.0 хувиар тус тус өссөн.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 32.7 сая төгрөгийн хохирлын 32.7 сая төгрөг буюу 100.0 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос хохирлын хэмжээ 3.0 сая төгрөг буюу 10.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 3.5 сая төгрөг буюу 1.7 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Багахангай дүүргийн цагдаагийн хэлтсийн хэмжээнд нийт 18594 зөрчил шалгасан нь өмнөх онтой харьцуулбал 13.5 хувиар, 18584 зөрчлийг шийдвэрлэсэн нь 13.5 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18221 буюу 98.0 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 38 буюу 0.2 хувийг Олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 22 буюу 0.1 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 303 буюу 1.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18434 иргэн, 9 хуулийн этгээдийг 718.6 сая төгрөгөөр торгож, 20 хүнийг баривчлуулах, 72 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 49 хүнийг баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оноос иргэнийг торгосон шийтгэл 13.7 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж шийтгэл 7.7 хувиар тус тус буурч, баривчлуулсан шийтгэл 2 буюу 11.1 хувиар, баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 69.0 хувиар тус тус өссөн байна.

2025 онд Багахангай дүүрэгт нийт 5 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оноос 15 буюу 75.0 хувиар, 16 хүнийг саатуулсан нь 62 буюу 79.5 хувиар тус тус буурсан байна.

---oooOooo---

2.9. НАЛАЙХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 3394 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1297 буюу 38.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2097 буюу 61.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оноос нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 385 буюу 12.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 23.4 хувиар тус тус өсөж, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1.0 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 248 буюу 19.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 975 буюу 75.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 33 буюу 2.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1751 буюу 83.5 хувийг зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан журмаар шийдэж, 285 буюу 13.6 хувийг зөрчил хүлээн авахаас татгалзсан, 50 буюу 2.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 314 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1 буюу 0.3 хувиар буурч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 0.9 хувийг эзэлж байна.




1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг (хороодоор).

Хороо	2024 он	2025 он	Өсөлт, бууралт	
			Тоо	Хувь
1-р хороо	67	80	13	19.4
2-р хороо	52	35	-17	-32.7
3-р хороо	34	48	14	41.2
4-р хороо	29	19	-10	-34.5
5-р хороо	26	38	12	46.2
6-р хороо	57	50	-7	-12.3
7-р хороо	21	20	-1	-4.8
8-р хороо	29	24	-5	-17.2

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 245 буюу 78.0 хувь нь хөнгөн, 69 буюу 22.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад хөнгөн хэрэг 9.6 хувиар буурч, хүнд хэрэг 56.8 хувиар өссөн байна.

1.5. Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Дүүргийн хэмжээнд сүүлийн 20 жил (2006-2025 он)-д бүртгэгдсэн 6650 гэмт хэргийн түүхэн дундаж өсөлтийг “хандлага сунгах” (trend-based extrapolation) аргыг ашиглан тооцоолбол ирэх 5 жилийн дундаж өсөлт 0.5%-тай байж, 2030 онд 307 орчим гэмт хэрэг бүртгэгдэх магадлалтай байна.

1.6. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн бүлгээр).

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2024 он	2025 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	2	-	-	-
	Үүнээс: Хүнийг алах	-	-	-	-
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	154	126	-18.2	40.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	19	18.8	6.1
	Үүнээс: Хүчиндэх	15	18	20.0	5.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.3
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.3
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	90	104	15.6	33.1

	Үүнээс:	Хулгайлах	24	37	54.2	11.8
		Дээрэмдэх	1	3	3.0 дахин	1.0
		Залилах	46	52	13.0	16.6
		Малын хулгай	1	1	0.0	0.3
